

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийн хэрэгжилт

Төрөөс МХХ-ны хөгжлийн талаар баримтлах бодлогын хүрээнд алслагдсан сум суурин газарт утасгүй интернэт үйлчилгээг хүргэх “Цахим сум” төслийн үр дүнг олон нийтэд танилцуулж, 2017 оны 6-р сарын 19-нд төслийн 3-р үе шатыг нээлээ. Төслийн хүрээнд 2017 онд 37 сум, суурин газарт утасгүй интернэтийн үйлчилгээг нэвтрүүлж, цаашид 300 гаруй алслагдсан сум, сууринд МЦХ ХК-ийн шилэн кабелийн үйлчилгээ болон утасгүй интернэтийн үйлчилгээ хүрэх юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны "Сумын төвийн ерөнхий боловсролын сургуулиудад интернэтийн үйлчилгээг хүргэх" төслийг үргэлжлүүлэн 2017 онд 243 сумын 254 сургуультай гэрээг шинэчлэн байгуулж, 118 сумын ЗДТГ болон эмнэлэгт интернэтийн үйлчилгээг хүргэсэн байна.

Цагдаагийн ерөнхий газартай хамтран харьяа байгууллагуудын телефон цэгүүдийг 7019-xxxx нэгдсэн дугаарлалтад шилжүүлэн, IP centrex үйлчилгээнд холбосон нь тус байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулсан, хэрэглэгчийн талархлыг хүлээн авсан үйлчилгээ болж чадсан. Ингэснээр тус байгууллагын нийт цэгийн тоо 40 гаруй хувиар нэмэгдсэн.

Хөнгөлөлт, урамшууллын хэвшмэл хөтөлбөрүүдээс татгалзан шинэлэг хэлбэрээр урт хугацааны “ҮНЭНЧ ХЭРЭГЛЭГЧДЭД” (Loyalty customer) чиглэсэн хөтөлбөр болон улирал бүрийн “Хэрэглэгчийн өдөрлөг”-ийг зохион байгуулалаа.

2017 оны нийт орлогын төлөвлөгөө 94%-ийн биелэлттэй, зардал төлөвлөснөөс 1,6 тэрбум төгрөгийн хэмнэлттэй гарч, цэвэр ашиг төлөвлөснөөс 361 сая төгрөгөөр давж биелэн, цэвэр ашгийн түвшин эерэг гаргасан амжилттай ажилласан.

Хэрэглэгчийн төлбөр тооцоог цахимжуулахад банкуудтай олон талаар хамтран ажиллаж байна. Байгууллага хэрэглэгчдийн төлбөрийг цахимжуулан, цаасан баримт хэвлэдэг зардлыг бууруулж чадсан. Мөн төлбөрийг QR код ашиглан төлөх боломжийг төлбөрийн системд нэвтрүүллээ.

Салбарт эзлэх байр суурь

Харилцаа холбооны салбарт суурин утасны зах зээлд эзлэх хувь 21,5 хувь байгаа нь Юнивинш ХХК (47.14%), Скаймедиа корпораци ХХК (21.63%)-ийн дараа 3-т орж байна. Суурин сүлжээн доторх ярианы нийт ачааллын хувьд 74.83%-ийг эзэлж давамгайл байдлаа хадгалж байна.

Томоохон үйл явдал


Монгол Улсын Засгийн газар КТ корпорацийн эзэмшлийн 40%-ийг буцаан худалдан авах шийдвэрийг 2017 оны 6-р сард гарган, худалдан авах хөрөнгийг 2018 оны төсөвт суулган зохих шийдвэрийг гаргасан.

Харилцаа холбооны орчин үеийн хэрэглээ нь интернэт, өгөгдлийн сүлжээн дээр суурилах болсон. Үүнтэй уялдуулан МЦХ ХК нь хэрэглэгчийн сүлжээний дэд бүтцээ шат дараатай шинэчлэн сайжруулахаар төлөвлөн хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаа. Тухайлбал, Siemens EWSD, Alcatel E10 тоон станцуудыг IP

суурьтай дараа үеийн сүлжээний технологид шилжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн. Телевизийн олон сувгийг агаараар дамжуулах үйлчилгээг нэвтрүүлэн, 7 аймгийн төв, 1 суурин газар DVB-T2 технологийг нэвтрүүллээ.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Нийт 3982 хувьцаа эзэмшигчтэйгээс томоохон хувьцаа эзэмшигч МУЗГ (54.67%), Корей телеком корпораци (40%) байна.



**Оны сүүлийн арилжаа явагдсан өдрөөр
Эх сурвалж: МХБ ХК*

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурал 2017 оны 4 дүгээр сарын 28-нд зохион байгуулагдсан. Хурлын ирц: 95.5 %.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсэн. Үүнд:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

3. Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт
4. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2017 оны зардлын төсвийг батлах
6. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэр, тогтоолыг танилцуулах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэр

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт - 99.9941 хувийн саналаар баталсан.
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт - 99.9941 хувийн саналаар баталсан.
3. Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт - 99.9941 хувийн саналаар баталсан.
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох - ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар санал хурааж сонгосон.
5. ТУЗ-ийн 2017 оны зардлын төсвийг батлах - 99.9941 хувийн саналаар баталсан.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 6, хараат бус 3 нийт 9 гишүүнтэй. 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж, сонгосон бөгөөд ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. Үүнд:

ТУЗ-ийн дарга

Жу Хён Мин КТ корпорацийн Харилцааны албаны дэд ерөнхийлөгч

Монгол улсын төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж буй гишүүд

Г.Эрдэнэбулган ЗГ-ийн хэрэг эрхлэх газар, Хууль, эрхзүйн газар, Засгийн газрын референт

О.Хуягцогт Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, Зарлагын хэлтсийн дарга

Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга

КТ Корпорацийн төлөөллийг хэрэгжүүлж буй гишүүд

Хонг Сик Жү МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч

И Үн Юн КТ корпорацийн Харилцааны албаны дарга

Хараат бус гишүүд

Ж.Тамир Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга

Л.Болормаа Төрийн банк, Захиргаа хүний нөөцийн хэлтсийн захирал

Кан Ён Мин Дунмён Их сургуулийн Тоглоом инженерчлэлийн тэнхимийн гэрээт профессор

Монголын цахилгаан холбоо ХК нь 2017 онд Улаанбаатар хот түүний алслагдсан 2 дүүрэг, 21 аймаг, 280 гаруй сум сууринд үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд нийт 768 гаруй ажилтан албан хаагчидтай. Улаанбаатарт 6 газар, 15 алба, Улаанбаатар хотын 4 бүсийн холбооны газар, аймаг дүүргийн 23 холбооны газартайгаар үйл ажиллагаа явууллаа. Гүйцэтгэх захирал, 2 дэд захирал, 6 газрын дарга удирдлагын багт ажиллаж байна. Компанийн эрх бүхий албан тушаалтанд ямар нэг өөрчлөлт, шинэ томилгоо хийгдээгүй байна.

Санхүүгийн чадавхийн талаар

Цэвэр эргэлтийн хөрөнгө, эргэлтийн харьцаа

Үзүүлэлт	2016 оны 12 сар	2017 оны 12 сар	Өөрчлөлт
Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0,47	0,48	0.01
Эргэлтийн харьцаа	4.8	7.6	2.8

Хүснэгт 1. Цэвэр эргэлтийн харьцааны харьцуулалт

Түргэн хөрвөх хөрөнгө, түүний харьцаа

Үзүүлэлт	2016 оны 12 сар	2017 оны 12 сар	Өөрчлөлт
Түргэн хөрвөх хөрөнгө	13,449,715.2	12,034,607.8	-1,415,107.40
Түргэн хөрвөх хөр. харьцаа	3.2	5.0	1.8

Хүснэгт 2. Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа

2017 оны 12-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад түргэн хөрвөх хөрөнгө 1,415.1 сая төгрөгөөр, дансны авлага 191.4 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	2016 оны 12 сар	2017 оны 12 сар	Өөрчлөлт
Ажлын цэвэр капитал	16,392,045.38	16,049,473.99	-342,571.40
Нийт хөрөнгөд эзлэх хувь	42%	45%	3%

Хүснэгт 3. Ажлын цэвэр капиталын харьцуулалт.

Ажлын цэвэр капитал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 342,5 сая төгрөгөөр буурч, нийт хөрөнгөд эзлэх хувь 3 хувиар өссөн байна.

Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Бие даах чадварын коэффициент

Үзүүлэлт	2016 оны 12 сар	2017 оны 12 сар	Өөрчлөлт
Бие даах чадварын коэффициент	0.78	0.81	0.03

Хүснэгт 4. Эздийн өмчийг нийт хөрөнгөнд харьцуулсан харьцаа

Санхүүгийн хамаарлын коэффициент

Үзүүлэлт	2016 оны 12 сар	2017 оны 12 сар	Өөрчлөлт
Санхүүгийн хамаарлын коэффициент	1.28	1.23	-0.05

Хүснэгт 5. Нийт хөрөнгийг эздийн өмчид харьцуулсан харьцаа

Зохицуулалтын коэффициент

Үзүүлэлт	2016 оны 12 сар	2017 оны 12 сар	Өөрчлөлт
Зохицуулалтын хамаарлын коэффициент	0.68	0.64	-0.04

Хүснэгт 6. Өөрийн эргэлтийн хөрөнгийг эздийн өмчид харьцуулсан харьцаа

Нийт өр төлбөрийн хувийн жин

Үзүүлэлт	2016 оны 12 сар	2017 оны 12 сар	Өөрчлөлт
Нийт өр төлбөрийн хувийн жин	0.22	0.19	-0.03

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийг нийт хөрөнгөнд харьцуулсан харьцаа

2017 онд цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин өмнөх оноос 2.8 пунктаар өсч харьцаа 7.6-д хүрсэн нь төлбөрийн чадвар улам сайжирсан, түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа мөн л өмнөх оноос 1.8 пунктаар өсч 5.0 хувь болсон нь мөнгө, ТБҮЦ, авлага зэргээр богино хугацаат өр төлбөрийг төлөх чадвар сайн байгааг харуулж байна.

Санхүүгийн бие даан үйл ажиллагаа явуулах чадварын хувьд санхүүгийн хамаарлын коэффициент өнгөрсөн 2016 оноос 0.05 пунктаар буурсан ч бие даах чадварын коэффициент 0.03-р өсч, бие даах чадвар 81%, санхүүгийн хамаарлын коэффициент 1.23 байгаа нь санхүүгийн үйл ажиллагаа нь гадны эх үүсвэрээс хараат бус, өөрийн санхүүжилтээр бие дааж үйл ажиллагаа явуулах чадвар сайн байгааг харуулж байна.

Монголын цахилгаан холбоо ХК
2018